



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/77

Мөрөн сум

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар 27.5.14, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал, амьтныг халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн өвчний тархвар зүй, голомтын судалгаанд үндэслэн 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулахыг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Мал сүргийг халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд голомт бүхий газар нутагт байгаа мал сүргийг бүрэн хамруулсан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нарт хариуцуулсугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН